



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.02.26 № 05/2082
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг буцаах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн дараах нэр дэвшигчдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахад:

1. Дашбалдангийн Жавхланг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар,
2. Лхагвасүрэнгийн Энхбатыг Цахим хөгжлийн газрын даргаар,
3. Мягмаржавын Оролзодыг Цахим хөгжлийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн мэдээллийн аюулгүй байдлын бодлого хариуцсан ахлах мэргэжилтнээр,
4. Баяраагийн Ундралыг Төрийн захиргааны удирдлагын газрын төлөвлөлгөө, тайлан, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтнээр,
5. Батмөнхийн Солонгыг Төрийн захиргааны удирдлагын газрын хууль хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр,
6. Бүнтэнгийн Эрдэнийг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын салбарын хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтнээр,
7. Чадраабалын Болор-Эрдэнийг Цахим хөгжлийн газрын Шуудан, радио телевизийн хэлтсийн радио телевизийн өргөн нэвтрүүлгийн асуудал хариуцсан мэргэжилтнээр,
8. Шаравжамцын Самданжамцыг Цахим хөгжлийн газрын мэдээллийн технологийн аудит, харилцаа холбооны дэд бүтэц хариуцсан мэргэжилтнээр,
9. Зундуйн Гантогоог Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргаар,
10. Эрдэнээгийн Бямбасүрэнг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын тоон контент хариуцсан ахлах мэргэжилтнээр,
11. Цогтын Долгосүрэнг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын судалгаа шинжилгээ, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтнээр,
12. Борчулууны Заяабаярыг Цахим хөгжлийн газрын Сансрын холбооны хэлтсийн сансрын холбооны технологи, хиймэл дагуулын координацын асуудал хариуцсан мэргэжилтнээр тус тус томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

0005159

Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Харин нэр дэвшигч З.Гантогоо нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д "төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс" томилно гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд тухайн албан тушаалд №- Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн этгээдийн нэр дэвшүүлж Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР